



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2014 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Төгсөлтийн дараах мэргэшлийн
сургалтын чиглэл, индекс
батлах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 8.1.9 дэх заалт, Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн хоёрдугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэжлийн сургалтын үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийг нэгдүгээр, төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэлийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв (Ч.Бат-Эрдэнэ), төгсөлтийн дараах мэргэшлийн сургалт эрхлэгч байгууллагуудын дарга/ захирал нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан "Эмнэлгийн мэргэжилтний давтан сургалтын чиглэл, индекс батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2011 оны 73 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ

Эрүүл мэндийн сайдын
2014 оны 08 сарын 17 өдрийн
192 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

Үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс

№	Сургалтын чиглэл	Индекс
1.	Дотор судлал	DR 72001
2.	Өрхийн анагаах ухаан судлал	DR 72002
3.	Хүүхэд судлал	DR 72003
4.	Мэдээгүйжүүлэг судлал	DR 72004
5.	Сэхээн амьдруулах эрчимт эмчилгээ судлал	DR 72005
6.	Яаралтай тусламж/гамшгийн үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ судлал	DR 72006
7.	Эх барих, эмэгтэйчүүд судлал	DR 72007
8.	Мэс засал судлал	DR 72008
9.	Гэмтэл- согог засал судлал	DR 72009
10.	Чих, хамар, хоолой судлал	DR 72010
11.	Нүд судлал	DR 72011
12.	Мэдрэл судлал	DR 72012
13.	Сэтгэц өвчин судлал	DR 72013
14.	Арьс судлал	DR 72014
15.	Халдварт өвчин судлал	DR 72015
16.	Хавдар судлал	DR 72016
17.	Сэргээн засал эмчилгээ судлал	DR 72017
18.	Анатомын эмгэг судлал	DR 72018
19.	Эмнэл зүйн эмгэг судлал	DR 72019
20.	Шүүхийн анагаахын судлал	DR 72020
21.	Дүрс оношлогоо судлал	DR 72021
22.	Уламжлалт анагаах ухаан судлал	DR 72022
23.	Зүү, төөнө засал судлал	DR 72023
24.	Нийгмийн эрүүл мэнд судлал	DR 72024
25.	Нүүр амны согог засал судлал	DR 72025
26.	Нүүр амны гажиг засал судлал	DR 72026
27.	Нүүр амны мэс засал судлал	DR 72027